



ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 1/24

Аварга

Өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллого зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын эд хөрөнгийн үзлэг, тооллогыг удирдан зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Өнөрбаяр

(Төсвийн ерөнхий нягтлан бодогч)

Гишүүд:

Ц.Лхагвадулам

(Нийгмийн даатгалын байцаагч)

С.Цэцэгсайхан

(Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)

Ц.Жаахансүрэн

(Улсын бүртгэгч)

Нарийн бичгийн дарга: Ц.Золзаяа

(Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Эд хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, заавар журмын дагуу албан хаагч тус бүрийн картаар хариуцсан эд хогшил, техник тоног төхөөрөмжийг нүд үзэж зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга (Х.Өнөрбаяр), гишүүдэд үүрэг болгосугай.

3.Тооллогдох эд хөрөнгө, техник тоног төхөөрөмжийг бэлэн байлгаж, тооллогын ажлыг мэргэжил арга зүйгээр хангаж, үндэсний статистикийн хорооноос баталсан маягт, гарын авлагаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Анхцэцэг), нярав (Л.Баатархүү)-д нарт үүрэг болгосугай.

4.2,4,5 дугаар багуудын төвийн эд хогшил, барилга байгууламжийн бүрэн бүтэн байдлыг нүд үзэж тооллого явуулах маршрутыг батлуулж ажиллахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Ц.Золзаяа)-д, тооллого явуулахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг 2,3,4,5 дугаар багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Эд хөрөнгийн үзлэг тооллогыг хууль тогтоомж, заавар, журмын дагуу зохион байгуулж, 2025 оны 12 дугаар сарын 25-ны дотор нэгтгэж дүнг нягтлан бодогч (О.Анхцэцэг), нярав (Л.Баатархүү) нарт хүлээлгэн өгөхийг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд даалгасугай.

ДАРГА  Д.УРАНГОО



СТС3350 182205 07 00733574